



САНГИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(2023 оны 6 дугаар сар)

Яамны газруудын 2023 оны 6 дугаар сарын үйл ажиллагааны биелэлтийг “Яамны дотоод бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-д заасан дараах 9 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд дундаж үнэлгээ **97.2 хувьтай** байлаа.



99.1%
Сарын төлөвлөгөө
24.8 оноо



97.0%
Албан бичгийн шийдвэрлэлт
9.7 оноо



100.0%
Шуурхай үүрэг даалгавар
5.0 оноо



95.4%
Ажлын цаг ашиглалт
9.5 оноо



100.0%
Үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал
10.0 оноо



98.4%
Жилийн төлөвлөгөө
19.6 оноо



98.8%
Аудитын зөвлөмж
9.8 оноо




87.6%
Хууль тогтоомж, тогтоол шийдвэр
4.3 оноо



98.9%
Бодлогын баримт бичиг
4.9 оноо

Шалгуур үзүүлэлтүүд /авах оноо/	ТБТГ	ТаБГ	НБББГ	СБГ	ХСХОГ	СТСГ	ТЗУГ	ТСГ	СХЭУГ	ХЭЗГ
	Авсан оноо	Авсан оноо	Авсан оноо	Авсан оноо	Авсан оноо	Авсан оноо	Авсан оноо	Авсан оноо	Авсан оноо	Авсан оноо
Сарын төлөвлөгөөний биелэлт /25 оноо/	25.0	23.7	25.0	24.4	25.0	25.0	24.6	25.0	25.0	25.0
Албан бичгийн шийдвэрлэлт /10 оноо/	9.5	9.4	10.0	9.5	9.9	9.2	9.6	10.0	10.0	9.9
Шуурхай үүрэг даалгаврын хэрэгжилт /5 оноо/	-	5.0	-	5.0	-	-	5.0	5.0	-	-
Ажлын цаг Ашиглалт /10 оноо/	9.4	9.6	9.1	9.7	9.7	9.5	9.5	9.1	10.0	9.9
Үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал /5 оноо/	5.0	5.0	5.0	5.0	5.0	-	5.0	-	5.0	5.0
Жилийн төлөвлөгөөний хэрэгжилт /20 оноо/	20.0	19.1	19.4	19.3	20.0	20.0	19.4	19.7	20.0	20.0
Аудитын зөвлөмжийн хэрэгжилт /5 оноо/	4.8	-	5.0	4.8	4.9	-	5.0	5.0	5.0	-
Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт /5 оноо/	4.6	4.5	3.2	4.3	4.7	4.7	4.7	5.0	4.5	-
Бодлогын баримт бичгийн хэрэгжилт /5 оноо/	5.0	5.0	-	4.7	4.9	5.0	5.0	5.0	-	5.0
НИЙТ	83.4	81.2	76.7	86.8	84.1	73.4	87.8 (-5)	83.8	79.5	74.8



Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А/116 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Яамны дотоод бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, үр дүнг үнэлэх журам”-ын дагуу яамны газруудын 2023 оны 6 дугаар сарын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ үнэлгээ, хийж, үр дүнг үнэлэхэд дунджаар **97.2 хувьтай** байна.

2023 оны 6 дугаар сарын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээгээр ХЭЗГ 99.7, СХЭУГ 99.3, ХСХОГ 99.0 хувиар тэргүүлж байна. 2023 оны 6 дугаар сарын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө хугацаа хоцроож батлуулсан тул журамд заасны дагуу ТЗУГ-ын авсан нийт онооноос 5 оноо хассан болно. /Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс үзнэ үү/



Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт (6 сар)

99.1
хувь

№	Газар	Нийт арга хэмжээ	Хэрэгжилт							Биелэлтийн хувь	Авсан оноо
			100	90	70	50	30	0	Үнэлэх боломжгүй		
1	ТБТГ	10	10	-	-	-	-	-	-	100.0%	25.0
2	ТаБГ	7	5	-	1	-	-	-	1	95.0%	23.7
3	НБББГ	16	16	-	-	-	-	-	-	100.0%	25.0
4	СБГ	51	43	-	4	-	-	-	4	97.4%	24.4
5	ХСХОГ	35	35	-	-	-	-	-	-	100.0%	25.0
6	СТСГ	7	7	-	-	-	-	-	-	100.0%	25.0
7	ТЗУГ	54	50	-	3	-	-	-	1	98.3%	24.6
8	ТСГ	29	29	-	-	-	-	-	-	100.0%	25.0
9	СХЭУГ	28	24	-	-	-	-	-	4	100.0%	25.0
10	ХЭЗГ	12	12	-	-	-	-	-	-	100.0%	25.0
НИЙТ		249	231		8	-	-	-	10	99.1%	24.8

Сангийн яам 2023 оны 6 дугаар сард нийт **249** ажил төлөвлөснөөс хэрэгжилт яамны дунджаар **99.1** хувьтай байна. Сарын төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээгээр ТБТГ, НБББГ, ХСХОГ, СТСГ, ТСГ, СХЭУГ, ХЭЗГ тус бүр 100 хувиар тэргүүлж байна.

СБГ-ын 4, ТЗУГ-ын 3, ТаБГ-ын 1 ажил тус бүр 70 хувийн үнэлгээтэй хэрэгжилтийн шатанд байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээнд хамруулаагүй 10 ажил байгаа ба үүнд яам, газрын удирдлагын шийдвэр, бусад байгууллагын үйл ажиллагаанаас хамааралтайгаар цуцлагдсан, хойшлогдсон, асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлт ирээгүй зэрэг шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй болсон ажлууд багтаж байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 2-оос үзнэ үү/



Албан бичгийн шийдвэрлэлт (6 сар)

97.0
хувь

Сангийн яаманд 2023 оны 6 дугаар сарын байдлаар нийт 2 743 албан бичиг ирснээс 2 031 бичгийн хариуг хугацаанд нь өгсөн бол хугацаа хоцроож боловсруулсан 22 албан бичиг байна. Албан бичгийн шийдвэрлэлт **97.0% хувьтай** байлаа. Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газарт 6 дугаар сарын байдлаар санхүүжилттэй холбоотой 285 албан бичиг ирснийг үнэлгээнд оруулаагүй болно. */Дэлгэрэнгүйг хавсралт 3-аас үзнэ үү/.*

№	Газар	Боловсруулж байгаа	Боловсруулсан	Боловсруулсан /хоцорсон/	Боловсруулж байгаа /хоцорсон/	Нийт	Хувь	Оноо
1	ТБТГ	27	144	7	-	178	95.4%	9.5
2	ТаБГ	30	79	4	1	114	94.0%	9.4
3	НБББГ	18	45	-	-	63	100.0%	10.0
4	СБГ	35	139	4	3	181	95.2%	9.5
5	ХСХОГ	143	569	2	1	715	99.5%	9.9
6	СТСГ	1	11	-	1	13	91.7%	9.2
7	ТЗУГ	43	85	2	2	132	95.5%	9.6
8	ТСГ	271	532	-	1	804	99.8%	10.0
9	СХЭУГ	3	45	-	-	48	100.0%	10.0
10	ХЭЗГ	107	382	3	3	495	98.5%	9.8
НИЙТ		678	2031	22	12	2743	97.0%	9.7

Яамны 2023 оны 6 дугаар сарын 5, 12, 19, 26-ны өдрүүдийн шуурхай хуралдаанаар Сангийн дэд сайд 6, ТНБД 11, нийт **17 үүрэг даалгаврыг** яамны газруудад өгсөн бөгөөд хэрэгжилтийн явц 2023 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар **100.0 хувьтай** байв. /Шуурхай үүрэг даалгаврын биелэлтийг хавсралт 4-өөс үзнэ үү/.

№	Хариуцсан газар	Шуурхай үүрэг даалгаврын тоо	Үнэлгээний дундаж	Авах оноо	Авсан оноо
1	ТБТГ	-	-	-	-
2	ТаБГ	2	100.0%	5	5.0
3	НБББГ	-	-	-	-
4	СБГ	6	100.0%	5	5.0
5	ХСХОГ	-	-	-	-
6	СТСГ	-	-	-	-
7	ТЗУГ	7	100.0%	5	5.0
8	ТСГ	2	100.0%	5	5.0
9	СХЭУГ	-	-	-	-
10	ХЭЗГ	-	-	-	-
НИЙТ		17	100.0%	5	5.0



Ажлын цаг ашиглалт (6 сар)

95.4
хувь

Яамны цаг бүртгэлийн системээс авсан мэдээллээр яамны ажлын цаг ашиглалт 2023 оны 6 дугаар сарын байдлаар дунджаар **94.6 хувьтай** байна.

№	Дотоод бүтцийн нэгж	Ажлын цаг ашиглалтын хувь	Авах оноо	Авсан оноо
1	ТБТГ	94.2%	10	9.4
2	ТаБГ	95.6%	10	9.6
3	НБББГ	90.9%	10	9.1
4	СБГ	96.7%	10	9.7
5	ХСХОГ	96.8%	10	9.7
6	СТСГ	94.9%	10	9.5
7	ТЗУГ	95.1%	10	9.5
8	ТСГ	91.1%	10	9.1
9	СХЭУГ	99.7%	10	10.0
10	ХЭЗГ	99.3%	10	9.9
НИЙТ		95.4%	10	9.5



Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал (6 сар)

100.0
хувь

Яамны холбогдох газрууд яамны эрхэм зорилго, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалт, үйлчилгээ, мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам, заавар, сангийн яамнаас олгож байгаа тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийг яамны цахим хуудсанд байршуулж, шинэчлэн ажилласан байна. 2023 оны 6 дугаар сарын байдлаар хэрэгжилт **100 хувьтай** байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 5-аас үзнэ үү/

№	Цахим хуудсанд мэдээлэл оруулсан газрууд	Үнэлгээ	Авах оноо	Авсан оноо
1	ТБТГ	100.0%	10	10.0
2	ТаБГ	100.0%	10	10.0
3	НБББГ	100.0%	10	10.0
4	СБГ	100.0%	10	10.0
5	ХСХОГ	100.0%	10	10.0
6	СТСГ	-	-	-
7	ТЗУГ	100.0%	10	10.0
8	ТСГ	100.0%	10	10.0
9	СХЭУГ	100.0%	10	10.0
10	ХЭЗГ	100.0%	10	10.0
НИЙТ		100.0%	10	10.0



Аудитын зөвлөмж (2023 оны эхний хагас жил)

98.8
хувь

Сангийн сайдын 2022 оны “Төлөвлөгөө батлах тухай” 174 дүгээр тушаалаар Үндэсний аудитын газраас Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайлан, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн Коронавируст халдвар /ковид-19/-ын эсрэг вакцинжуулалтын арга хэмжээг дэмжих төслийн хөрөнгийн ашиглалт, үр дүнд хийсэн аудитын тайлан, Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайлан, Сангийн яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан болон бусад холбогдох аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулан, мөрдөж ажиллаж байна.

2023 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээнд давхардсан тоогоор нийт 75 зөвлөмж бөгөөд газар тус бүрээр хүснэгтээр харуулбал: .

№	Газар	Нийт	Хэрэгжилтийн үнэлгээ					Биелэлтийн хувь
			100	70	30	0	-	
1	ТБТГ	9	8	1	-	-	-	96.6%
2	ТСГ	8	8	-	-	-	-	100%
3	СБГ	27	24	3	-	-	-	96.6%
4	ХСХОГ	19	18	1	-	-	-	98.4%
5	ТЗУГ	9	9	-	-	-	-	100%
6	НБББГ	2	2	-	-	-	-	100%
7	СХЭУГ	1	1	-	-	-	-	100%
8	ХЭЗГ	-	-	-	-	-	-	-
9	ТаБГ	-	-	-	-	-	-	-
10	СТСГ	-	-	-	-	-	-	-
НИЙТ		75	70	5	-	-	-	98.8%



Бодлогын баримт бичгийн хэрэгжилт (2023 оны эхний хагас жил)

98.9
хувь

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд ерөнхий дүнгээр 97.4 хувьтай байна.

“Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-д тусгагдсан арга хэмжээний 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд ерөнхий дүнгээр 100.0 хувьтай байна. 2023 оны Эхний хагас жилийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ 98.85 хувьтай байна. ТСГ, ТаБГ, ТЗУГ, СТСГ, ХЭЗГ 100.0, ТБТГ 99.0, ХСХОГ 97.5 хувиар тэргүүлж байна. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг 2023 оны эхний хагас жилийн байдлаар газар тус бүрээр хүснэгтээр харуулбал:

№	Газар	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	Хэрэгжилтийн дундаж
1	ТБТГ	98%	100%	99%
2	СБГ	88.6%	100%	94.3%
3	ХСХОГ	95.00%	100%	97.50%
4	ТБГ	100%	-	100%
5	ТСГ	100.00%	100%	100.00%
6	НБББГ	-	-	-
7	ХЭЗГ	100%	-	100%
8	СХЭУГ	-	-	-
9	ТЗУГ	100%	100%	100%
10	СТСГ	-	100%	100%
НИЙТ				98.9%



Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт (2023 оны эхний хагас жил)

87.6
хувь

Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэрт тусгагдсан, Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 397 зүйл, заалтуудын хэрэгжилтэд СХЭУГ-аас Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгон 2023 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнд үнэлгээ өгсөн.

Сангийн яам, түүний харьяа байгууллагууд Монгол Улсын хуулийн 52, Улсын Их Хурлын тогтоолын 63, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын 59, Ерөнхийлөгчийн зарлигт тусгагдсан 6, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжид тусгагдсан 3, Засгийн газрын тогтоолд тусгагдсан 101, Ерөнхий сайдын захирамжид тусгагдсан 1, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлд тусгагдсан 107, Засгийн газрын албан даалгаварт тусгагдсан 6 нийт 397 зүйл заалтыг тайлант хугацаанд хяналтад авч ажиллав. 2023 оны эхний хагас жилийн байдлаар эдгээр хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт **87.6** хувьтай байлаа. Хэрэгжилтийг харьяа байгууллагуудын хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээг хасаж, яамны газар тус бүрээр харуулбал:

№	Газар	Нийт /Давхардсан тоогоор/	Хэрэгжилтийн үнэлгээ					Хэрэгжилтийн хувь
			100	70	30	0	Үнэлэх боломжгүй	
1	ТБТГ	93	55	9	3	-	26	92.8%
2	ТСГ	10	8	-	-	-	2	100%
3	СБГ	124	70	24	9	-	21	86.9%
4	ХСХОГ	57	38	6	1	-	12	94.4%
5	ТЗУГ	45	31	4	1	-	9	94.7%
6	НБББГ	22	7	5	8	-	2	64.5%
7	СХЭУГ	4	2	1	-	-	1	90.0%
8	ХЭЗГ	-	-	-	-	-	-	-
9	ТаБГ	43	22	12	-	-	9	89.4%
10	СТСГ	5	4	1	-	-	-	94.0%
НИЙТ								87.6%

Дүгнэлт

1. Яамны 2023 оны 6 дугаар сард нийт төлөвлөсөн 279 ажлаас 92.7 хувийг бүрэн хэрэгжүүлж ажилласан ба харин 3.2 хувийг хэрэгжүүлж дуусаагүй (үүнд: 78ажил) байна.
2. Газруудын албан бичиг шийдвэрлэлтийн байдал 97.0 хувьтай байна. 6 дугаар сард хариу өгөх хугацааг хоцроож шийдвэрлэсэн 22, хоцроон боловсруулж буй 12 албан бичиг байна.
3. 2023 оны 6 дугаар сард яамны шуурхай хуралдаан 4 удаа хуралдаж, Дэд сайд 6, ТНБД 11 нийт 17 үүрэг даалгаврыг яамны газруудад өгсөн бөгөөд хэрэгжилтийн явц 6 дугаар сарын эцсийн байдлаар 100.0 хувьтай байна.
4. 2023 оны 6 дугаар сарын яамны газруудын ажлын цаг ашиглалт дунджаар 95.4 хувьтай байна.



Зөвлөмж

1. 2023 оны 6 дугаар сарын төлөвлөгөөнд гүйцэтгэхээр төлөвлөсөн боловч хэрэгжилтийн шатанд буюу удаашралтай байгаа ажлуудыг газрууд дараа сарын төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж дуусгах;
2. Сарын биелэлтийг тайлагнахдаа хийсэн ажлын үр дүн, ач холбогдлыг бүрэн гүйцэд, товч, тодорхой бичиж, огноо, албан бичгийн дугаар зэрэг баримт мэдээллийг оруулж, шаардлагатай тайлан мэдээллийг хавсаргаж, дараа сарын 5-ны дотор тайлагнаж хэвших;
3. Албан бичгийн хугацаанд нь шийдвэрлэж буй эсэхэд газар, хэлтсийн удирдлагаас тавих, хяналтыг сайжруулах, хариу өгсөн, шийдвэрлэсэн тухай мэдээллийг албан бичгийн бүртгэлийн системд тухай бүрд нь оруулж хэвших;
4. Шуурхай үүрэг, даалгаврын биелэлтийг газрууд долоо хоног бүрийн Пүрэв гарагт хяналт-шинжилгээ, үнэлгээний ЛМ-3 цахим системд хугацаанд нь тогтмол тайлагнаж хэвших;
5. Газар, хэлтсийн ажлын цаг ашиглалтыг сайжруулахад газар, хэлтсийн удирдлагаас тавих, хяналтыг сайжруулах.
6. Газрын сарын төлөвлөгөөг хугацаанд нь боловсруулж, батлуулахад газар, хэлтсийн удирдлагаас тавих, хяналтыг сайжруулах.